

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Автомашинны техникийн үйлчилгээ, засвар. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS XXXX:XXXX
Occupational safety and health. Automotive technical service and repair. General safety requirements.	MNS 0012-3-004:1983 оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандарт нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр ашиглагдаж байгаа ачааны, суудлын автомашин, автобус, чиргүүл, хагас чиргүүл, зүтгүүрийн техникийн үйлчилгээ, урсгал засварын бүх төрлийн ажлуудыг ашиглалтын байгууллага, техникийн үйлчилгээний газар болон тусгайлсан төвүүд дээр гүйцэтгэхэд мөрдөх аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтооно.

Хийн ба хатуу түлшээр ажилладаг автомашин, мөн автомашин дээр байрлуулсан тусгай төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, урсгал засварын аюулгүй ажиллагааны шаардлагыг энэ стандартаар тогтоохгүй.

1. Хамрах хүрээ

Автомашин засвар үйлчилгээний үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтан, тоног төхөөрөмж, ажлын орчин, үйл явцад мөрдөх нөхцөлийг аюулгүй ажиллагааны шаардлагуудыг тогтооно.

2. Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

“Авто үйлчилгээ-Ангилал, ерөнхий шаардлага” MNS 5025:2010

Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага зөвшөөрөгдөх хэмжээ MNS 4990:2023

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Сургалтын зохион байгуулалт. үндсэн дүрэм” MNS 4969:2023

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Цахилгаан тоног төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсэг

Цахилгаан эрчим хүчийг дамжуулж, төхөөрөмжийг ажиллуулахад ашиглагддаг металл эд анги, холболт

3.2 Материалын гадаргууны хэт халалт

Тухайн материалын гадаргуу дээр зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү температур үүсэх үзэгдэл

3.3 Эргэдэг стэнд

Тухайн нөхцөл, орчны шаардлага хангасан зориулалтын тухайн эд анги, үзүүлэн, тоног төхөөрөмжийг байрлуулах, турших, үзүүлэх зориулалттай байгууламж

3.4 Эбонитоор хийсэн савх

Хатуу резин материалаар хийсэн, цахилгаан, физикийн туршил эсвэл сургалтын хэрэглээнд зориулагдсан саваа

3. Ерөнхий шаардлага

4.1 Техникийн үйлчилгээ, урсгал засварын явцад үйлдвэрлэлийн аюултай хортой доорх хүчин зүйлүүд үйлчилж болно. Үүнд:

- Хөдөлж байгаа автомашин, бусад машин механизмууд, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хамгаалагдаагүй, хөдөлгөөнт хэсэг, зөөгдөж байгаа бүтээгдэхүүн, бэлтгэл эд материалууд
- Ажлын байранд бэлэн бүтээгдэхүүн, багаж хэрэгсэл, материалыг хэт бөөгнөрүүлж саатуулах
- Техникийн үйлчилгээ, урсгал засварын байр, зогсоолд автомашиныг буруу байрлуулах
- Зохих технологийн дагуу ажлыг явуулахад зориулалтын багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, материалын гадаргууны хэт халалт
- Ажлын бүс дэх эрүүл ахуйн нормоос хэтэрсэн агаарын урсгалын хурд, чийглэг, температур
- Шалган-оношлох, засварлах ажлын үед ажлын байрны эрүүл ахуйн нормоос хэтэрсэн шуугиан, доргион
- Цахилгаан тоног төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсэг хамгаалалтгүй байх
- Ажлын бүсийн гэрэлтүүлэг хангалтгүй байх
- Ажилтнуудын арьс, амьсгалын зам, хоол боловсруулах систем болох харах, үнэрлэх эрхтний салст бүрхүүлээр дамжин нөлөөлж болох харах, үнэрлэх эрхтний салст бүрхүүлээр дамжин нөлөөлж болох хэрэглэгдэж буй материалын найрлагад байгаа хорт бодис

4.2 Техникийн үйлчилгээ, урсгал засвар хийх үед Зам тээврийн яамны баталсан тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журмыг мөрдлөг болгоно.

4.3 Хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь Зам тээврийн яамнаас тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журамд заасан шаардлагыг хангах нөхцөлийг.

4.4 Техникийн үйлчилгээ, урсгал засвар хийх үед Зам тээврийн сайдын баталсан тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журмыг дагаж мөрдвөл зохино.

4.5 Техникийн үйлчилгээ, урсгалын засварын ажил явуулах дараах үе шатуудад,

аюулгүй ажиллагааг хангасан байна. Үүнд:

- автомашиныг техникийн үйлчилгээ, урсгал, засварт бэлтгэхэд;
- техникийн үйлчилгээ, урсгал засварын ажлыг шууд гүйцэтгэж байхад;
- автомашины системүүдийг шалгаж, туршихад;
- автомашиныг шатахуун, тосолгооны материал болон бусад тусгай шингэнээр цэнэглэхэд;
- автомашин, эд анги, агрегат, материалыг хадгалах, тээвэрлэхэд;
- үйлдвэрлэлийн хаягдлыг зайлуулах, хоргүй болгоход;

4.6 Техникийн үйлчилгээ, засварын ажил хийх явцад үйлдвэрлэлийн байр, талбай орчны агаарын бохирдолт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байх нөхцөлийг.

4.7 Техникийн үйлчилгээ, засварын ажил хийх үед эвдэрхий, бүрэн бус тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглахыг хориглоно.

5.Технологийн процесст тавих шаардлага

5.1 Техникийн үйлчилгээ, урсгал засварын объектыг бэлтгэх, тухайн ажлыг гүйцэтгэх, ажлын байрыг цэвэрлэх зэрэг ажиллагаанд аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөх нөхцөлийг.

5.2 Техникийн үйлчилгээ, урсгал засварын ажлыг тусгай зориулалтын байр, талбайд тодорхой ажил бүрд зориулан бэлдсэн тоног, төхөөрөмж багаж, хэрэглэлийг ашиглаж гүйцэтгэнэ.

5.3 Автомашиныг техникийн үйлчилгээ, урсгал засварт оруулахын өмнө сайтар угааж цэвэрлэвэл зохино.

5.4 Техникийн үйлчилгээ, урсгал засварын байранд тавигдсан автомашины дугуйнд хоёроос доошгүй тулгуур хийж, найдвартай бэхлэх, гар тормосыг татаж, хүнд араанд нь залгана. Дотоод шаталтат хөдөлгүүртэй автомашины асаалтын системийг салгана. Дизель хөдөлгүүртэй автомашины түлш өгөлтийг хаана. Жолооны хурд дээр нь “Хүмүүс ажиллаж байна. Асаахыг хориглоно” гэсэн анхааруулгыг заавал өлгөнө.

5.5 Автомашинд өргөгч хэрэглэн засвар үйлчилгээ хийж байгаа үед өргөгчийн удирдлагын механизм дээр “Хүмүүс ажиллаж байна. Хүрч болохгүй” гэсэн бичгийг өлгөнө. Өргөгчийг ажлын байрлалдаа өөрөө гэнэт буухаас хамгаалсан найдвартай тулгууртай байх нөхцөлийг.

5.6 Урсгал дамжлагын шугам дээр байгаа постууд нь шаардлагатай үед аль ч постоос автомашины шилжилтийн хөдөлгөөнийг яаралтай зогсоох боломж бүхий дохио, холбоогоор тоноглогдсон байх ёстой. Автомашиныг нэг постоос нөгөө постод шилжүүлэх ажиллагаа нь зөвхөн бүх постуудаас ажил дууссан тухай дохио авч, шилжүүлэх хөдөлгөөн эхлэх болсныг мэдэгдэн, анхааруулсан дохиог бүх постуудад өгсний дараа явагдана. Энэхүү анхааруулга болгон ашигласан дуут дохионы түвшин нь ажлын байранд 6-8 ДБА-аас хэтрэхгүй байвал зохино.

5.7 Эргэдэг стэнд дээр байрлуулсан автомашиныг стендын зохих бэхлэх хэрэгслээр найдвартай бэхлэж, түлш шингэнийг юүлэн, аккумуляторыг салган авч, бэхлэгдээгүй бүх зүйлийг бүхээг, тэвш заалнаас зайлуулна.

5.8 Автомашины их өндөрт байрласан агрегат эд ангид үйлчилгээ, засвар хийхдээ тогтвор сайтай гишгүүр, тавиур эсвэл шат хэрэглэвэл зохино.

5.9 20 кг-аас илүү жинтэй агрегат, зангилааг өргөж, шилжүүлэхдээ зөвхөн өргөж-тээвэрлэх механизмын тусламжтайгаар гүйцэтгэнэ.

5.10 Агрегатыг өргөж-тээвэрлэх механизмаар өргөж, тээвэрлэхдээ зөвхөн тухайн төрлийн ажлыг гүйцэтгэхэд зориулсан тусгай хэрэглэлийг ашиглан тээвэрлэх схемийн дагуу гүйцэтгэх ёстой.

5.11 Нэг тал нь өргөх механизмаар өргөгдсөн боловч нөгөө хэсэг нь тусгай суурь – тавиур дээр байрлаагүй ямар нэг ачааг автомашин дээр гүйцэтгэхийг хориглоно.

5.12 Шингэнээр дүүргэгдсэн эд анги, агрегатыг автомашинаас буулгах ажлыг зөвхөн шингэний нь бүрэн юүлж зайлуулсны дараа гүйцэтгэнэ.

5.13 Автомашины хөдөлгүүр, эд анги, агрегатыг угааж цэвэрлэх, ажлыг зөвхөн эдгээрт зориулж бэлтгэсэн уусмал бүхий тусгай сав, угаах төхөөрөмжүүдэд гүйцэтгэнэ.

5.14 Этилжүүлсэн бензинээр ажилладаг хөдөлгүүр, тосолгооны аппаратын эд ангиуд, агрегатыг угаах ажлыг зөвхөн тетраэтилсвинцийн үлдэгдлийг нь урьдчилан бүрэн цэвэрлэсний дараа гүйцэтгэнэ.

5.15 Дутуу шаталтын эсрэг хольц бүхий бензинээр ажилладаг хөдөлгүүрийн тэжээлийн системийн техникийн үйлчилгээ, урсгал засварын ажлыг түүний угсаргааны нэгжүүдийг хэвийн байрлалд байрлуулсны дараа гүйцэтгэнэ.

5.16 Автомашиныг асаахын өмнө гар тормосыг татаж, залгагч хөшүүргийг сул байрлалд тавина.

5.17 Хөдөлгүүийг гар эргүүлгээр асаах үед нэмэлт хөшүүрэг, хүч нэмэгдүүлэгч зэргийг хэрэглэх ба эргүүлгийг гарын бугуйгаар уургалж барихыг хориглоно. Эргүүлгийг доороос дээш нь эргүүлнэ.

5.18 Хөдөлгүүрийг асааж, автомашиныг байрнаас нь хөдөлгөхдөө дээр нь ажиллаж байгаа болон ойр байгаа ажилтнуудын аюулгүй ажиллагааг хангасан байх нөхцөлийг.

5.19.Автомашины явах ангийн дор (тэвшний) тусгай тулгуур байрлуулж, нумнаас (ачааллын) жинг чөлөөлсний дараа нум авах, байрлуулах, ажлыг гүйцэтгэнэ.

5.20 Ачааны тэвшний өргөх механизмыг солих, засварлахдаа тэвшийг унахаас болгоомжилж, түүний дор нэмэгдэл тулгуур хийсний дараа гүйцэтгэнэ.

5.21 Техникийн үйлчилгээ, урсгал засварын технологийн дагуу хөдөлгүүр заавал асаалттай байх шаардлагатайгаас бусад тохиолдолд үйлчилгээ, засварын хөдөлгүүр асаагүй үед гүйцэтгэнэ.

5.22 Хөдөлгүүрийн тахир гол эсвэл кардан голыг эргүүлэхийг өмнө асаалтын систем салсан (дизель хөдөлгүүр-түлш хаалттай) эсэхийг заавал шалгаж, араа залгах хөшүүргийг сул байрлалд тавина.

5.23 Тэжээлийн системийг шахсан агаар бүхий түгээх системтэй холбогдсон агаарын насосоор үлээж цэвэрлэнэ. Энэ үед түгээх системийг агаарын даралт 0,5

МПа-аас хэтрэхгүй байх ёстой.

5.24 Автомашины тоормосыг зориулалтын стэнд дээр шалгаж, турших шаардлагатай. Гэвч туршилтыг тусгай талбай дээр явуулж болно. Харин энэ үед тоормосны зай нь тормос гэмтэлтэй тохиолдолд ч ажилтнуудын аюулгүй байдлыг хангасан байх нөхцөлийг.

5.25 Түргэн асдаг, тэсэрч дэлбэрэх аюултай ачаа тээвэрлэдэг автомашинд техникийн үйлчилгээ, урсгал засвар хийхийн өмнө газардуулга хийх нөхцөлийг.

5.26 Аккумуляторын зайг салгаж, унахаас болгоомжилсон тусгай төхөөрөмжөөр бэхлэж байрлуулна.

5.27 Аккумуляторын зайг цэнэглэх, үйлчилгээ засвар хийх зэрэг бүх ажлыг зориулалтын дагуу тусгайлан төхөөрөмжилсөн байранд явуулна.

5.28 Зориулалтын тусгай саванд хийсэн усанд хүчлийг аажмаар нэмж шил буюу эбонитоор хийсэн савхаар сайтар хутгаж найруулах замаар электролитыг бэлтгэнэ.

5.29 Цэнэглэхээр байрлуулсан аккумуляторын шонгуудыг оч үүсэхгүй байдлаар хавчиж гүйдэл үүсгэгчтэй холбоно.

5.30 Аккумуляторын зайг цэнэглэх үед секцүүдийн бөглөөг сулласан байх нөхцөлийг.

5.31 Автомашины рам засварлах ажлыг тусгай тавиур, эсвэл автомашин дээр нь гүйцэтгэнэ. Тавиур дээр засварлах үед рамыг тогтвортой байрлуулсан байх нөхцөлийг.

5.32 Засварлахаар автомашинаас салгаж авсан бүхээг, тэвшийг тусгай тавиур буюу стэнд дээр ажиллахад тохиромжтойгоор байрлуулна.

5.33 Шаврын хаалт болон хуудсан төмрөөр хийсэн бусад эд ангийг засварлаж, анхны хэв маяг хэлбэрт нь оруулах ажлыг автомашин дээр нь эсвэл тусгай стэнд дээр гүйцэтгэх ёстой.

5.34 Галын аюул гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор автомашин дээрх гагнуурын ажлыг Галын аюулгүй байдлын тухай хуулийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

5.35 Шатахуун, тосолгооны материалын банк, савыг гагнах ажлыг тэдгээрийг бүрэн шавхаж, уурыг тусгай агаараар бүрэн цэвэрлэсний дараа гүйцэтгэнэ.

5.36 Эд ангийг их хүч гарган салгаж авахаар бол (Жишээ нь: пүрш гэх мэт) тусгай багажаар гүйцэтгэнэ.

5.37 Резин дугуйг задлах, угсрах ажлыг зөвхөн зориулалтын багаж, хэрэгсэл, төхөөрөмжийн тусламжтай, тусгай хамгаалалттайгаар гүйцэтгэвэл зохино.

5.38 Дугуйн бул цоожлох цагираг эвдэрч гэмтээгүй нөхцөлд угсарна. Угсрах үед цоожлох цагираг нь булынхаа хоногт (суваг) бүрэн суусан эсэхийг шалгах хэрэгтэй.

5.39 Хэрэв дугуйн хийн даралт нормын хэмжээнээс 40%-иас илүү буурсан бол дугуйг автомашинаас нь салгахгүй хийлэхийг хориглоно.

5.40 Цоожлох цагирагтай дугуйг хийлэхдээ цагираг мултарч үсрэхээс хамгаалсан

тусгай хамгаалалттай ажиллах хэрэгтэй.

6. Автомашиныг задгай талбайд хадгалах, үйлдвэрлэлийн байранд тавих шаардлага

6.1 Автомашиныг хадгалах үйлдвэрлэлийг байр, задгай талбай нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар тогтоосон норм, хэмжээ, шаардлагыг хангасан байх нөхцөлийг.

6.2 Үйлдвэрлэлийн байрны шал нь тэгш бөгөөд техникийн үйлчилгээ, урсгал засвар хийх явцад ашиглагдах элдэв хорт бодисын үйлчилгээнд тэсвэртэй, түүнчлэн ус тогтоохооргүй тэгш байвал зохино.

6.3 Автомашин хадгалах байрны бүх ханын дагуу дугуйн тулгуур, хамгаалалт хийх нөхцөлийг.

6.4 Техникийн үйлчилгээний суваг, тавцангууд (экстакад) нь бүх уртынхаа дагуу дугуй чиглүүлэгч, хамгаалалтын хашлагатай байвал зохино.

6.5 Хорт бодис, уур тос гэх мэт зүйлүүд гарч болзошгүй үйлдвэрлэлийн хэсгүүд нь бусад байрнаасаа тусгаарлагдсан байх нөхцөлийг.

6.6 Автомашин хадгалах, засварлах байр, задгай талбай нь тэдгээрийг байрлуулан тавихад зориулагдсан, хурц тод, өнгийн будгаар хийгдсэн тэмдэглэгээ, заагтай байх нөхцөлийг.

6.7 Суваг, шуудуу, хонгил нь агааржуулалтын системээр тоноглогдсон, явахад чөлөөтэй байх нөхцөлийг.

6.8 Ажлын байрны агаар нь MNS 4990:2023, MNS 4969:2023 стандартын батлагдсан зохих норм, хэмжээнд байх нөхцөлийг.

6.9 Техникийн үйлчилгээ, урсгал засвар хийх байр автомашин хадгалах талбай нь агааржуулалтын системээр бүрэн тоноглогдсон байх нөхцөлийг.

6.10 Асаалттай автомашинд техникийн үйлчилгээ хийх байр ялгарч буй хийг зайлуулах төхөөрөмжөөр тоноглогдсон байх нөхцөлийг.

6.11 Автомашин ба эд анги угаах байр нь үйлдвэрийн бусад байрнаас тусгаарлагдсан байвал зохино.

6.12 Тосыг дахин боловсруулах, аккумуляторыг цэнэглэх, будаг зэрэг тэсрэмтгий бодис ялгаруулдаг байр нь бусад байртай холбоогүй тусдаа агааржуулалтын системээр тоноглогдсон байх нөхцөлийг.

6.13 Гадагш зайлуулагдаж байгаа агаар нь зохих шаардлагын дагуу цэвэрлэгдэж байх нөхцөлийг.

6.14 Ажлын байрны шуугиан, доргион чичиргээний түвшин нь зохих шаардлагыг хангаж байвал зохино.

6.15 Автомашин хадгалах байр нь үйлдвэрийн бусад байр, агуулахаас шууд дамжин орох орцгүй, тусдаа байх ёстой.

6.16 Үзлэгийн суваг болон бусад амархан бохирдож болох байрны ханын дотор

талыг цэвэрлэхэд хялбар материалаар барих хэрэгтэй.

7. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг байрлуулах, ажлын байрыг зохион байгуулахад тавих шаардлага

7.1 Үйлдвэрлэлийн байранд тоног төхөөрөмжийг ажилтнуудын аюулгүй ажиллагааг хангасан технологийн үйлдэл хийхэд тохиромжтой байдлаар байрлуулж, зохион байгуулах хэрэгтэй.

7.2 Хийх ажлын төрлөөс хамааруулан ажлын байр бүрийг шаардлагатай багаж, хэрэгсэл, техникийн аюулгүй ажиллагааны үзүүлэн материалаар бүрэн тоноглогдсон байх нөхцөлийг.

7.3 Ажлын байр нь чөлөөтэй байхаас гадна шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг авч хэрэглэхэд аль болохоор хялбар ойр, эвтэй унахааргүй байрлуусан байвал зохино.

7.4 Хүйтэн шалтай (цемент, асфальт г.м материалаар хийсэн) байранд ажилтнуудын зогсох газар сараалж модоор тавцан гишгүүр хийж тавиад зохино.

7.5 Үзлэгийн сувгийн дээгүүр хөдлөн тавьсан дамнуур гарцын өргөн нь 0,8 м-ээс доошгүй байх ёстой. Гарцын тоо нь суваг дээр байрлуулсан автомашинаас нэгээр цөөн байна.

7.6 Үзлэгийн суваг, тавцангийн гадна талд, өргөгчөөс зайдуу газар автомашинд техникийн үйлчилгээ, засвар хийх үед ажлын байр тэргэнцэрээр хангагдсан байвал зохино.

8. Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хаягдлыг тээвэрлэх, хадгалахад тавих шаардлага

8.1 Техникийн үйлчилгээ, урсгал засварын пост, хадгалах байр, задгай талбайд автомашиныг байрлуулахдаа тэдгээрийн хоорондын зай, мөн автомашин, барилга байшин, тоног төхөөрөмжийн хоорондын зайг ажилтнуудад саад гэмтэл учруулахгүй байхаар тооцоолж гүйцэтгэнэ.

8.2 Аюултай болон хортой шинж чанар бүхий эд юмс, материалыг хадгалах, тээвэрлэхдээ ажилтнуудыг гэмтээх, хордуулах түлэх, бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхгүй аргаар гүйцэтгэвэл зохино.

8.3 Хэт урт, овор ихтэй эд анги, агрегатыг (гол, тэнхлэг, нум г.м) хадгалах, тээвэрлэхдээ өөрөө гулсаж унахаас сэргийлсэн тусгай төхөөрөмж хэрэгслийн тусламжтай гүйцэтгэнэ.

8.4 Галд тэсвэргүй шингэн зүйл хадгалах савыг зохих дүрэм, заавар шаардлагын дагуу байрлуулна.

8.5 Үйлдвэрлэлийн хог хаягдлыг тусгай зориулалтын газар болон саванд хадгална.

8.6 Шингэн түлш тээвэрлэдэг автомашиныг задгай газар эсвэл бусад автомашинаас тусад нь тусгай газар хадгална.

8.7 Автомашин хадгалах талбайд шатахуун юүлэх, цэнэглэхийг хориглоно.

9. Үйлдвэрлэлийн ажилтнуудад тавих шаардлага

9.1 Ажилчид, инженер, техникийн ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, техникийн ба галын аюулгүй дүрмээр сургаж, шалгалт авч, зааварчилгаа өгсний дараа ажилд оруулна.

9.2 Инженер техникийн ажилтнуудыг жилд 2-оос доошгүй удаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургаж, шалгалт авч байна.

9.3 Сургалт, зааварчилгыг холбогдох яам, албан байгууллага, үйлдвэрчний эвлэлийн хорооноос баталсан программын дагуу явуулна.

9.4 Ажилтнуудад дараах дэс дарааллаар зааварчилгаа өгнө. Үүнд:

9.4.1 урьдчилсан-ажилд орох үед нь:

9.4.2 ажлын байрны – анхан шатны ажлын байран дээр:

9.4.3 давтан-3 сард 1-ээс доошгүй удаа:

9.4.4 төлөвлөгөөт бус – дүрэмд /өөрчлөлт орох, технологи өөрчлөгдөх, шинээр тоног төхөөрөмж суурилуулж ашиглах үед/

10. Хамгаалах хэрэгслийн ашиглалтад тавих шаардлага

10.1 Ажилтнууд нь үйлдвэрлэлийн төрөл бүрийн аюултай бөгөөд хортой хүчин зүйлийн нөлөөллөөс урьдчилан хамгаалах зорилгоор хамгаалах хэрэглэлийг хэрэглэх ёстой.

10.2 Ажилтнууд нь холбогдох салбарынхаа нормативын дагуу ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байх нөхцөлийг.

11. Аюулгүй ажиллагааны шаардлагын биелэлтэд тавих хяналт

11.1 Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага зөвшөөрөгдөх хэмжээ MNS 4990:2023, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Сургалтын зохион байгуулалт. үндсэн дүрэм” MNS 4969:2023 стандартын шаардлагыг хангасан байх нөхцөлийг.

11.2 Технологийн процесс, ажлын горим, өөрчлөгдөх, тоног төхөөрөмж солигдох болон бусад арга хэмжээнээс болоод ажлын бүсийн агаарын найрлага өөрчлөгдөж муудсан үед зөвшөөрөгдөх параметруудын ээлжит бус шалгалтыг явуулах шаардлагатай.

11.3 Ажлын байрны шуугиан, доргионы хэмжээг зохих стандартын дагуу шалгаж байна.

11.4 Цахилгаан аюулгүй байдлыг Зам тээврийн сайдын баталсан Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журмын дагуу шалгана.

11.5 Байгууллагын захиргаанаас, үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран явуулах шалгалт нь жилд нэгээс доошгүй удаа зохиогдож байвал зохино.

ТӨГСӨВ.